



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Б.Бямбатогтох  
Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 77  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН 2 ДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Н.НЯМААНЯМБУУ ТАНАА

#### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>92,857,468.78</b>	<b>94,587,903.35</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	890,542.28	890,542.28
33300	Татаас, санхүүжилтийн авлага	890,542.28	890,542.28
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	91,966,926.50	93,697,361.07
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	88,444,782.50	87,746,024.55
35110	Тусгай зориулалттай материал	87,348,082.50	87,122,524.55
35130	Эм боох материал	1,096,700.00	623,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	3,522,144.00	5,951,336.52
35410	Бичиг хэргийн материал	919,240.00	2,963,590.00
35420	Аж ахуйн материал	2,602,904.00	2,987,746.52
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,567,541,875.80</b>	<b>2,490,847,377.10</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,567,541,875.80	2,490,847,377.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,430,251,875.86	1,353,667,377.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,374,322,064.73	1,374,322,064.73
39202	Хуримтлагдсан элэгдэл	(120,522,594.87)	(181,127,163.15)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,842,459.23	180,397,165.31
39206	Хуримтлагдсан элэгдэл	(108,691,910.85)	(118,790,000.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	93,973,825.74	93,401,628.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,620,516.81)	(62,178,171.64)
39209	Зам, гүүрийн байгууламж	95,561,938.77	95,561,938.77
39210	Хуримтлагдсан элэгдэл	(18,613,390.08)	(27,920,085.12)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	1,137,289,999.94	1,137,179,999.90
39301	Програм хангамж	1,100,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(715,000.06)	(275,000.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,136,905,000.00	1,136,905,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,660,399,344.58</b>	<b>2,585,435,280.45</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>742,729.77</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	742,729.77
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	742,729.77
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	91,868.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	650,861.77
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	650,861.77
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,523,494,344.58</b>	<b>2,584,692,550.68</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,523,494,344.58	2,584,692,550.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	778,795,397.17	1,915,700,397.17
51101	Өмч: - төрийн	778,795,397.17	778,795,397.17
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(58,047,941.43)	(133,754,735.33)
51210	Өмнөх үеийн үр дүн	(58,047,941.43)	(58,047,941.43)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(75,706,793.90)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	802,746,888.84	802,746,888.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,523,494,344.58</b>	<b>2,585,435,280.45</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>600,953,213.80</b>	<b>829,476,914.76</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,646,261.80</b>	<b>5,627,578.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,646,261.80	5,627,578.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,564,061.80	5,627,578.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	117,000.00	325,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		3,515,400.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	1,447,061.80	1,787,178.40
120009	Бусад орлого	82,200.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>599,306,952.00</b>	<b>823,849,336.36</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	570,135,352.00	760,130,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,586,352.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	566,549,000.00	760,130,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,783,736.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,783,736.36
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29,171,600.00	58,935,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,171,600.00	58,935,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>630,579,736.78</b>	<b>905,183,708.66</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>630,579,736.78</b>	<b>905,183,708.66</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	625,012,536.78	867,607,097.53
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	479,656,615.95	634,412,234.72
210101	Үндсэн цалин	311,299,956.64	364,955,585.72
210102	Нэмэгдэл	140,551,533.31	220,068,465.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	448,350.00	2,320,000.00
210104	Урамшуулал	27,356,776.00	47,068,184.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	62,946,939.00	83,956,978.27
210201	Тэтгэврийн даатгал	44,530,404.00	59,013,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,564,900.00	6,367,373.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,103,200.00	5,093,438.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,898,800.00	1,273,494.05
210205	Эрүүл мэндийн даатгал	8,849,635.00	12,209,472.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,595,028.01	36,058,109.26
210301	Гэрэл, цахилгаан	5,757,183.01	11,853,279.85
210302	Түлш, халаалт	12,401,677.94	17,973,065.41
210303	Цэвэр, бохир ус	2,436,167.06	6,231,764.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	12,565,130.00	11,054,240.22
210401	Бичиг хэрэг	115,975.00	319,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	248,565.00	100,146.39
210404	Ном, хэвлэл	157,100.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,619,200.00	1,714,857.48
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,811,750.00	4,140,750.00
210408	Бараа материал актгалсны зардал	6,612,540.00	4,778,936.35
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	420,600.00	1,078,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	219,100.00	843,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	201,500.00	235,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	218,400.00	2,807,100.00
210604	Урсгал засвар	218,400.00	2,807,100.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	56,000.00
210702	Дотоод албан томилолт	-	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,008,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	47,601,823.82	98,183,935.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,458,400.00	7,074,036.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,143,423.82	91,109,898.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	5,567,200.00	37,576,611.13
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,485,000.00	26,396,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,017,500.00	25,596,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	467,500.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	82,200.00	9,170,090.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	82,200.00	9,170,090.74
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	2,009,920.39
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,009,920.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(29,626,522.98)</b>	<b>(75,706,793.90)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(29,626,522.98)</b>	<b>(75,706,793.90)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,915,700,397.17	802,746,888.84	(58,047,941.43)	2,660,399,344.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,915,700,397.17	802,746,888.84	(58,047,941.43)	2,660,399,344.58
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,915,700,397.17	802,746,888.84	(58,047,941.43)	2,660,399,344.58
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,915,700,397.17	802,746,888.84	(58,047,941.43)	2,660,399,344.58
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,915,700,397.17	802,746,888.84	(58,047,941.43)	2,660,399,344.58
D08	Тайлант үеийн үр дүн			(75,706,793.90)	(75,706,793.90)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,915,700,397.17	802,746,888.84	(133,754,735.33)	2,584,692,550.68

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(1)</b>	<b>854,690,299.00</b>	<b>826,692,705.36</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,012,300.00</b>	<b>325,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,012,300.00	325,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	930,100.00	325,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	930,100.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		325,000.00
120009	Бусад орлого	82,200.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>853,677,999.00</b>	<b>826,367,705.36</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	781,388,000.00	760,130,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	781,388,000.00	760,130,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,980,600.00	6,632,536.36
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,783,736.36
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,980,600.00	1,848,800.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	46,539,100.00	58,935,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,539,100.00	58,935,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	23,770,299.00	669,569.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	23,770,299.00	669,569.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>854,728,181.00</b>	<b>815,792,705.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>854,728,181.00</b>	<b>815,792,705.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>801,087,472.82</b>	<b>777,546,525.23</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	660,914,441.92	633,669,504.95
210101	Үндсэн цалин	412,380,498.67	361,557,141.00
210102	Нэмэгдэл	199,892,346.25	222,053,785.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,004,808.00	2,389,800.00
210104	Урамшуулал	45,636,789.00	47,668,778.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	83,269,671.44	83,956,978.27
210201	Тэтгэврийн даатгал	61,765,713.44	59,013,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,454,000.00	6,367,373.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,083,100.00	5,093,438.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,898,800.00	1,273,494.05
210205	Эрүүл мэндийн даатгал	10,068,058.00	12,209,472.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,021,944.46	36,058,109.26
210301	Гэрэл, цахилгаан	9,629,540.87	11,853,279.85
210302	Түлш, халаалт	20,250,883.23	17,973,065.41
210303	Цэвэр, бохир ус	5,141,520.36	6,231,764.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,133,015.00	8,396,132.75
210401	Бичиг хэрэг	322,900.00	593,136.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	248,565.00	100,146.39
210404	Ном, хэвлэл	292,400.00	1,757,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,203,200.00	803,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,065,950.00	5,142,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	843,500.00	904,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,000.00	370,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	599,500.00	534,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,310,900.00	2,807,100.00

210604	Урсгал засвар	1,310,900.00	2,807,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	56,000.00
210702	Дотоод албан томилолт	-	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,988,600.00	1,848,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,980,600.00	1,848,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,605,400.00	9,849,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	434,500.00	267,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,170,900.00	9,581,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,640,708.18</b>	<b>38,246,180.13</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	35,092,581.00	27,066,169.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,770,299.00	669,569.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,422,900.00	25,596,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	899,382.00	800,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	18,548,127.18	9,170,090.74
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,548,127.18	9,170,090.74
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	2,009,920.39
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,009,920.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(37,882.00)</b>	<b>10,900,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(37,882.00)</b>	<b>10,900,000.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	828,077,800.00	809,529,772.82	819,995,600.00	797,310,688.87
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	828,077,800.00	809,529,772.82	819,995,600.00	797,310,688.87
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	817,206,700.00	799,106,872.82	793,597,900.00	770,913,988.87
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	665,980,000.00	660,914,441.92	633,848,100.00	633,669,504.95
210101	Үндсэн цалин	417,926,000.00	412,380,498.67	394,142,500.00	361,557,141.00
210102	Нэмэгдэл	199,513,700.00	199,892,346.25	192,095,000.00	222,053,785.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,400,000.00	3,004,808.00	1,480,200.00	2,389,800.00
210104	Урамшуулал	44,140,300.00	45,636,789.00	46,130,400.00	47,668,778.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	85,878,800.00	83,269,671.44	84,505,800.00	83,956,978.27
210201	Тэтгэврийн даатгал	59,239,600.00	61,765,713.44	59,036,200.00	59,013,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,659,800.00	5,454,000.00	6,367,400.00	6,367,373.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,327,800.00	4,083,100.00	5,093,900.00	5,093,438.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,332,000.00	1,898,800.00	1,273,500.00	1,273,494.05

210205	Эрүүл мэндийн даатгал	13,319,600.00	10,068,058.00	12,734,800.00	12,209,472.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	45,228,200.00	35,021,944.46	45,228,200.00	36,058,109.26
210301	Гэрэл, цахилгаан	11,363,200.00	9,629,540.87	11,363,200.00	11,853,279.85
210302	Түлш, халаалт	27,266,000.00	20,250,883.23	27,266,000.00	17,973,065.41
210303	Цэвэр, бохир ус	6,599,000.00	5,141,520.36	6,599,000.00	6,231,764.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,133,700.00	13,133,015.00	5,887,600.00	5,595,396.39
210401	Бичиг хэрэг	322,900.00	322,900.00	365,500.00	359,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	249,200.00	248,565.00	550,400.00	100,146.39
210404	Ном, хэвлэл	292,400.00	292,400.00	292,400.00	292,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,203,200.00	10,203,200.00	426,200.00	553,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,066,000.00	2,065,950.00	4,253,100.00	4,290,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	843,500.00	843,500.00	1,012,400.00	904,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,000.00	244,000.00	370,500.00	370,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	599,500.00	599,500.00	641,900.00	534,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,310,900.00	1,310,900.00	13,707,100.00	2,807,100.00
210604	Урсгал засвар	1,310,900.00	1,310,900.00	13,707,100.00	2,807,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	218,200.00	-	365,500.00	56,000.00
210702	Дотоод албан томилолт	218,200.00		365,500.00	56,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,008,000.00	1,008,000.00	672,800.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,605,400.00	3,605,400.00	8,370,400.00	7,866,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	434,500.00	434,500.00	446,100.00	267,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,170,900.00	3,170,900.00	7,924,300.00	7,598,400.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,871,100.00	10,422,900.00	26,397,700.00	26,396,700.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	10,871,100.00	10,422,900.00	26,397,700.00	26,396,700.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,871,100.00	10,422,900.00	25,597,600.00	25,596,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			800,100.00	800,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	827,927,100.00	810,309,072.82	819,065,600.00	808,210,688.87
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	781,388,000.00	773,046,128.36	760,130,300.00	758,120,379.61

131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	781,388,000.00	773,046,128.36	760,130,300.00	758,120,379.61
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	46,539,100.00	36,332,844.46	58,935,300.00	49,765,209.26
132001	Орон нутгийн төсвөөс	46,539,100.00	36,332,844.46	58,935,300.00	49,765,209.26
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-	-	100.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-	-	100.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	930,100.00	-	325,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	930,100.00	-	325,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	-	-	-	-
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	-	-	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	-	-	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	55.00	55.00	55.00	55.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	39.00	39.00	39.00	39.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	15.00	15.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>55.00</b>	<b>55.00</b>	<b>55.00</b>	<b>55.00</b>
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	35.00	35.00	35.00	35.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	20.00	20.00	20.00	20.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>6,632,536.36</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>6,632,536.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	6,632,536.36
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	2,800,736.36
210401	Бичиг хэрэг		233,736.36

210404	Ном, хэвлэл		1,465,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		852,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	1,848,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,848,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	1,983,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,983,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>6,632,536.36</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		6,632,536.36

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Бямбатогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

2 дугаар сургууль нь ерөнхий боловсрол эзэмшүүлэх зорилготой боловсролын байгууллага юм.

Суралцах хүсэл тэмүүлэлтэй, эрүүл бие бялдар, зөв дадал хэвшил, эерэг хандлагатай хүүхэд төлөвшүүлэх зорилготой, дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

- Сургуулийн хүүхэд хамгааллын хөтөлбөрийг багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой хэрэгжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх,
- Хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургах,
- Суралцагч бүрийг зөв дадал хэвшилд сургах.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТХууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2 дугаар сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 819,995.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,299.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,224.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,422.1 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	91,966.9	93,239.4	1,272.5
Үндсэн хөрөнгө	2,567,541.9	2,490,847.4	(76,694.5)
Богино хугацаат өр төлбөр		650,861.77	650,861.77

<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,660,399.3</b>	<b>2,584,977.3</b>	<b>(75,422.0)</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,660,399.3	2,584,977.3	(75,422.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,660,399.3</b>	<b>2,584,977.3</b>	<b>(75,422.0)</b>

Бараа материалын данс 93,239.4 мянган төгрөг болж 1,272.5 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын үлдэгдэл өмнөх оноос 222.2 хувиар, аж ахуйн материалын үлдэгдэл өмнөх оноос 14.8 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,490,847.4 мянган төгрөг болж 76,694.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд томоохон хөрөнгө бүртгээгүй, 91,109.9 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,584,977.3 мянган төгрөг болж 75,422.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2 дугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 698.0 мянган төгрөгөөр буюу 1.4 хувиар буурсан, нийт зардал өмнөх оноос 19,177.5 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар тус тус буурсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

2 дугаар сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 992,112.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 992,112.1 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 431,279.9 мянган төгрөгөөр бууруулан 560,832.2 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 1 удаа тодотгол хийж 259,163.4 мянган төгрөгөөр өсгөж, 819,995.6 мянган төгрөгөөр баталжээ. Тодотголоор цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, урсгал засварын зардлыг нэмэгдүүлжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх ерөнхий боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 760,130.3 мянган төгрөгийг улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр, орон нутгийн төсвөөс 58,935.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны ажиллагааны орлогоос 325.0 мянган төгрөг төвлөрч, урсгал үйл ажиллагаанд 808,210.6 мянган төгрөгийг зарцуулж, 11,784.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 808,210.7 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 178.6 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 548.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,170.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 292.2 мянган төгрөг, нормативт зардлыг 107.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 672.8 мянган төгрөг, томилт зочны зардлыг 309.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БСШУСЯамны “Инээмсэглэл дүүрэн бидний ирээдүй” төслөөс 233.7 мянган төгрөгийн бичиг хэрэг, 1,465.0 мянган төгрөгийн ном хэвлэл, 250.0 мянган төгрөгийн хог хаягдал зайлуулах, 852.0 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс, 1,983.0 мянган төгрөгийн хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

2 дугаар сургууль нь 2021 онд нийт 783,312.8 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй, 681,618.1 мянган төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулж, хуулийн хугацаанд мэдээлж, 101,694.7 мянган төгрөгийн 2 орлогын гүйлгээг мэдээлээгүйг аудитын явцад залруулж тайлагнуулсан.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшууллыг илүү тооцоолж олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-дэх заалттай, үндсэн хөрөнгийн тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8,265.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 424.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	0	0					
Албан шаардлага	1	8,265.9	1	8,265.9			
Зөвлөмж	2	424.1	2	424.1			
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>8,690.0</b>	<b>3</b>	<b>8,690.0</b>			

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 132,971.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 126,922.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 702.0 мянган төгрөгт 1 төлбөрийн акт, 5346.6 мянган төгрөгийн албан шаардлага, 2,429.2 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

- Шилэн дансанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 101,694.7 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүйг залруулж тайлагнуулав,
- Люминарторын машин, баримт үдэгч, цаас зүсэгч, гар бөмбөг зэрэг 1,074.4 мянган төгрөгийн материалыг бичиг хэргийн материалд орлогоор бүртгэж зарлагадсаныг тусгай зориулалтын материалд бүртгүүлж тайлагнуулав,
- Акталсан 4,778.9 мянган төгрөгийн бараа материалыг бараа материалын тодруулга тайланд зарцуулснаар тайлагнасныг бусад хэсэгт залруулж тайлагнуулав,
- Үндсэн хөрөнгө худалдан авсан 10,900.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авснаар тайлагнуулав,
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын 1,787.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 3,515.4 мянган төгрөгийг нэгтгэн тайлагнасныг тус тусад нь залруулж тайлагнуулав,
- Нийгмийн даатгалын шимтгэлийн даатгуулагчийн 1 хувийн зөрүү 650.9 мянган төгрөгийг ажилчдад олгоогүй, ХХОАТ-н тайланг зөрүүтэй тайлагнаж 91.9 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүйг өглөгөөр бүртгүүлж тайлагнуулав.

## **4.2 Төлбөрийн акт**

### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

“Инээмсэглэл дүүрэн бидний ирээдүй” төслийн хэрэгжээгүй төсөл арга хэмжээний зардлыг 2021 оны 12 сарын 17-ны өдрийн А/61, 2021 оны 12 сарын 20-ны өдрийн А/62 дугаар тушаалаар сургалтын менежерийн данс руу 702.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **1.2 Шийдвэрлэсэн нь:**

Төлбөрийн акт хүргүүлэв.

## **4.3 Албан шаардлага**

### **2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

#### **2.1 Илрүүлэлт:**

Нийт ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна сургуулийн захирлын 2021.12.17-ны өдрийн А/60 дугаар тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс нийт 5,346.6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-р хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын, 3-д “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 02-р сарын 01-ны өдрийн А/35, А/10/9 тушаалаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт”-н 2-д “Ур чадварын нэмэгдлийг албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг, багшлахуй, суралцахуйн үйлийг бүтээлчээр хэрэгжүүлж онцгой амжилт гаргасан, шинийг санаачлан хэрэгжүүлж үр дүнд хүрсэн, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлсэн багш, ажилтанд энэхүү баримт бичгийн 3.4.5-д заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан олгоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### **2.2 Шийдвэрлэсэн нь:**

Албан шаардлага хүргүүлэв.

## **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **3. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

#### **3.1. Илрүүлэлт:**

Тайлант оны 1-11 саруудад 1,412.8 мянган төгрөгийн бичиг хэрэг, 2,095.1 мянган төгрөгийн аж ахуйн материал орлогодож зарцуулсан байна. Гэтэл зөвхөн 12 дугаар сард 5,229.8 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 3,147.6 мянган төгрөгийн аж ахуйн материал орлогодож, 3,162.8 мянган төгрөгийн бичиг хэрэг, 1,673.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг зарлагдаж, бичиг хэргийн материал 2,963.6 мянган төгрөг, аж ахуйн материал 2,987.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны үлдэгдлийг өмнөх онтой харьцуулахад бичиг хэргийн материал 2,044.3 мянган төгрөгөөр, аж ахуйн материал 384.8 мянган төгрөгөөр өсжээ. Үүнээс харахад тус сургууль нь төсвийн хэмнэлтээс бараа материал нөөцөлж бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр бэлтгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2 дугаар сургууль	9	132,971.2	6	126,922.6	1	702.0	1	5,346.6	1	2,429.2